

## 10

ОРЧУУЛГА ХАМ СЭДЭВ (CONTEXT)-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

Ц. Баярмаа

Орчуулга хийхэд тухайн хоёр хэлний хангалттай мэдлэгээс гадна, орчуулга хийгдэж буй сэдвийн тодорхой мэдлэг зайлшгүй шаардагдах нь ойлгомжтой боловч хам сэдвээс тухайн үг, өгүүлбэрийн уттыг тааж олох мэдрэмж орчуулагчид зайлшгүй байх ёстой. Орчуулагч Р.Гүрбазар “Хам сэдэв гэдэг нь эх зохиолд гарч буй үгийн олон салаа утгаас тухайн нөхцөлд орчуулж байгаа хэлээр чухам аль үгийг, ямар утгаар сонгон хэрэглэх нь ойр хавийн өгүүлбэр, бүлэг өгүүлбэр, тэр ч байтугай зохиол бүтээлийн бүхэл хэсэг буюу бүх зохиолын түвшин, ургуулан бодох чадварын нэг шалгуур мөн.”<sup>31</sup> гэжээ.

Төрөл бүрийн орчуулгад хам сэдвээс хамаарсан, хоорондоо уялдаа холбоо бүхий, битүү утга агуулсан олон тооны хэллэгүүд тохиолддог учир орчуулагч хамгийн наад зах нь эх зохиол бичигдсэн хэлний хэл зүйн адarmaатай бүтциүүдийг судалж мэдсэн байх хэрэгтэй байна. Өгүүлбэрээр илэрч буй нэг утгын цаана мөн давхар утга явж байдгийг ч орчуулагч хүн нарийн мэдрэч байх хэрэггэй байдаг. Энгийн нэг жишээ авахад ‘Some of my friends came here’ гэхэд цаана нь ‘Some of my friends didn’t come here’ гэсэн утга гарч байгааг орчуулгад давхар анхаарч байх хэрэгтэй. Үүнийг олон улсын орчуулгын нэр томъёонд заримдаа “invisibility” гэх бөгөөд ‘далд утга’ гэж монголоор нэрлэж болох юм. Ийнхүү өгүүлбэрт буй далд уттыг илрүүлэхэд хам сэдвийн үүрэг асар их тул олон талын мэдлэг чадвар, уран сэтгэмж, аливаа зүйлийн зүй тогтолцыг нээн олох мэдрэмж, уйгагүй эрэл хайгуул болон чинхүү оролдлого л үнэн зөв бөгөөд чанартай сайн орчуулга хийх үндэс болно.

<sup>31</sup> Р.Гүрбазар, “Орчуулгын онол, дадлагын үндэс”, УБ 1996 №.93

Орчуулагч эх хэлний өгүүлбэрийн бүтцийн агуулж буй утгыг тайлж олоод тэрхүү уттыг алдагдуулахгүйгээр нөгөө хэлний бүтцээр илэрхийлэх үйл ажиллагаа явуулдаг. Энд өөрчлөгдөж буй зүйл бол өгүүлбэрийн бүтэц болон тэмдэгтүүд, харин өөрчлөгдөхгүй үлдэж буй ганц зүйл бол *утга* юм. Утгыг гаргахад үгийн түвшинд, өгүүлбэрийн түвшинд болон хам сэдвийн түвшинд авч үздэг. Орчуулгын онолд хам сэдвийг явцуу (*micro-context*) ба өргөн (*macro-context*) гэж ялгадаг хэмээн дуун хөрвүүлэгч Ц.Цэдэндамба “Орчуулгын үндэс” номдоо өгүүлжээ. “Явцуу хам сэдэв гэдэг нь тухайн орчуулах гэж буй үгийн багтаж орсон нийлэмж үг болон өгүүлбэр, харин өргөн хам сэдэвт зэрэгцээ өгүүлбэрээс гадна догол ба шинэ мөр болон бүхэл бүтэн бүлэг ч багтана.”<sup>32</sup> гэж мөн тэрээр дурьдсан байна.

## 1. Үгийн түвшинд утга гаргах

Явцуу хам сэдвийн хүрээнд нийлмэл үг дээр жишээ авахад “United Nations” гэхийг монголоор “нэгдсэн үндэстнүүд” гэхгүй “Нэгдсэн үндэсний байгууллага” гэж орчуулснаас харахад үгийг орчуулахад хам сэдвээс гадна тэр үгээр нэрлэгдэж буй “хэлний бус нэгжийг” үгийн орчуулгад тусгах шаардлага гардаг болохыг харуулж байна. Мөн АНУ-д замын жолооч нарт үйлчилдэг, машинаасаа гаралгүй, хачиртай талх мэт бэлэн хоол авч идэхэд тохиromжтой хоолны газрууд олноор байдаг бөгөөд эдгээрийг “Drive-through” гэж нэрлэдэг. Энэ нийлмэл үгийг, жишээ нь толь бичгээс хараад орчуулах боломжгүй тул (машинд нь үйлчлэх) “замын хоолны газар” юмуу “зам зуур” гэх зэрэгээр утгыг тайлбарлаж орчуулахаас өөр аргагүй юм. (Манай Улаанбаатарт Ленины музейн (хуучнаар) урд талбайд үйлчилгээ явуулдаггүй нэг ийм англи хаягтай цэг байдаг).

Англи хэлэнд баяртай мэдээ сонссон хүн “I’m glad (to hear that)” гэж хэлэх нь яриа болон уран зохиолын хэл найруулагад түгээмэл хэрэглэгддэг. “Ээжийн бие сайжирч байгаа” эсвэл “би жолооны шалгалтандaa тэнцүүхээ” гэхэд хариуд нь “би (үүнийг сонсохдоо) баяртай байна” гэх нь монгол ахуйд огт тохироогүй сонсогддог. Үүнийг ялангуяа киноны орчуулгад хэрэглээд бараг хэвшиж байх шиг байна. Манайхан ийм тохиолдолд “за яамай даа, ашгүй дээ, болж дээ, яасан сайн юм бэ” гэх мэтчилэн сонссон зүйлдээ таашаалтай буйгаа илэрхийлдэг билээ. Орчуулагч орчуулж буй зохиолоо хэл найруулгын хувьд аль болохоор ард түмнийхээ сэтгэлгээнд ойр байлгахыг хичээх хэрэгтэйг дараах жишээ харуулж байна. Азербайджаны ардын яруу найрагч Самед Вургун 1943 онд А.С.Пушкины “Евгений Онегин” романыг хэрхэн орчуулснаа ярихдаа: “...үндэснийхээ онцлогийг алдчихгүйсэн гэхдээ эхнэрээ гүйж эгшигт хайрцаг тавиулж, хөгжмийн аяар би орчуулж байлаа. Тэгэхгүй бол “Евгений Онегин” хүчтэй давалгаагаараа намайг тэр чигээр нь хамж аваад явчих гээд байсан”<sup>33</sup> гэсэн байдаг.

<sup>32</sup> Ц.Цэдэндамба, “Орчуулгын үндэс”<sup>33</sup> Д.Дашдаваа, “Уран зохиолын орчуулгын тухай”, УБ 1988 №.88

Киноны орчуулгад хэлний бус орчин буюу үйл явдал өрнөж буй орчин мон хам сэдвийн үүрэг гүйцэтгэдэг. Жорж Лукасын ‘Temple of Doom’ кинонд Индиана Жонес Виллис Скот нар зочид буудлын орооноос өрөө рүү шилжин муудалцаж явах үед Индигийн “knock it off” (чи болж уз дээ гэсэн хэлц) хэмээн хэлэхийг дуу оруулагч “чи яагаад хаалга тогисонгүй вэ?” гэж хөрвүүлж байх юм. Тэр ярианы үед ингэж хэлэх нь ямар ч авцалдаагүй байгааг ядаж орчны байдлаас нь дүгнэх хариуцлага орчуулагч хүнд байх хэрэгтэй юм.

Энд хэлний бус орчныг үгийн түвшний орчуулгад буруу тусгасан нэг сонирхолтой жишээ дурьдахад дэлхийн хоёрдугаар дайны үед холбоотны цэрэг давшиж байхдаа Германы радио холбоог нууцаар чагнаад *Der Abt ist im Kloster* гэсэн өгүүлбэрт буй *Abt* буюу ширээт лам (англиар *Abbot*) гэсэн үгийг герман хэлний *Abteilung* буюу цэргийн батальон (англиар *battalion*) гэдэг үгийн товчлол гэж ойлгоод “Сүм дотор цэргийн батальон байна” хэмээн хорвүүлснээс болж холбоотны цэрэг Италийн Монте Касино сүмийг тэр чигт нь дэлбэлж байсан байна.<sup>34</sup>

Мөн аливаа хэлний зүйрлэл болон хэлц хэллэгүүд нөгөө хэл рүү үгчлэн орчуулагддаггүй. Академич, доктор профессор Бичээч овогт Д.Томортогоо “Тухайн нэгэн ард түмний хэл, сэтгэлгээний бодит толь болсон өвөрмөц, хэлц хэллэгүүдийг нөгөө хэлэнд шууд үгчлэн буулгах боломж маш бага, харин тэдгээрийн адил төстэй утга санаа илэрхийлсэн оор хэлц, хэллэгээр дүйлгэн буулгах нь илүү тохиromжтой байлаг байна.”<sup>35</sup> гэжээ. Жишээ нь “Do as Romans do while in Rome” гэхийг монголоор “Усыг нь уувал ёсыг нь дага”, “Set a beggar on horseback and he will ride to the devil” – “Гар бариад бугуй барих”, эсвэл “Оровдөхөд ор өшиглох” “Laugh in one’s sleeve”- “Наашаа харж уйлж, наашаа харж инсэх” гэх мэт. Мөн англи хэлэнд ямар нэг зүйлийг цээжлэн тогтоо утгыг “learn by heart” хэмээн зүрхтэйгээ зүйрлэж яридаг байхад манай монголчууд үүнийг “цээжлэх” хэмээн цээж эрхтнийг оролцуулан яридаг билээ. Манай нэрт сэтгүүлч Ц.Дашдондов өвөрмөц болон хэлц хэллэгийн орчуулгын тухайд: “...дан утгыг бус далд нуугдмал давхар утгыг нээж тайлах, тэгэхийн тулд тохирох эквивалентыг нь олж оноох нь үгийг үгээр махчилж орчуулахаас тогогтэй.”<sup>36</sup> хэмээсн нь хам сэдэв үгийн орчуулгын түвшинд ч ямар чухал байдгийг харуулж байна.

## 2. Өгүүлбэрийн түвшинд утгыг гаргах

Хоёр хэлний өгүүлбэрийн бүтцийн ялгаатай байдлуудаас болоод өгүүлбэрийн түвшинд утгыг орчуулж гаргах илүү ярвигтай байдаг. Зөвхөн ганц салангид өгүүлбэрийн бүтцэд баригдан утга гаргана гэдэг боломжгүй зүйл юм. Иймд өгүүлбэр хоорондын уялдаа холбоог нарийн ойлгож, утгын авцалдааг бодож орчуулахгүй бол зохиогчийн хам сэдвийн хүрээнд хэлцэд байгаа санаа алдагдаж

<sup>34</sup> B.Hatim, Jeremy Munday, “Translation: An advanced resource book” 2005, x 34

<sup>35</sup> Д.Дашдондов, “Монгол-Англи өвөрмөц хэлц хэллэгийн толь” УБ 2001, x.3

<sup>36</sup> Д.Дашдондов, “Монгол-Англи өвөрмөц хэлц хэллэгийн толь” УБ 2001, x. 6

унишигчийг төөрөгдүүлэхэд хүрч болзошгүй юм. Жишээ нь англи хэлний харьцуулсан бүтцүүд дээр давхар утга (*ambiguity*) гарч ирдэг.

- Харьцуулсан дайвар гишиг өгүүлбэрүүд

Англи хэлэнд харьцуулалт хийгдэж буй дайвар гишиг өгүүлбэрийн зарим хэсгийг орхиж бичдэг. “She is taller than her sister (is).” Зарим ийм тохиолдлуудад өгүүлбэрийн утгыг таахад бэрхшээл учирдаг.

Жишээ-1: *Mr. Alton will pay you more than Stan.*

Энэ өгүүлбэрийн утгыг дараах хоёр байдлаар тайлж болох юм.

1. *Mr. Alton will pay you more than (he will pay) Stan.* - Ноён Алтон танд Станд толох байснаасаа шуу монгол толох болно.

2. *Mr. Alton will pay you more than Stan (will pay you).* - Ноён Алтон танд Стани танд толохоос шуу монгол толох болно.

Жишээ-2: *Parents dislike homework as much as their offspring.*

Энэ өгүүлбэрийг мөн хам сэдвийн хүрээнд авч үзэхгүй бол хоёрдмөл утга агуулж байгааг харж болно.

1. *Parents dislike homework as much as their offspring (dislike homework).* - Энэг эхчүүд үр хүүхдүүдийнхээ нэгэн адил гэрийн ажилд дургүй байдаг.

2. *Parents dislike homework as much as (they dislike) their offspring.* - Энэг эхчүүд үр хүүхдүүдээ дургүй байдаг шигээ гэрийн ажилд мон дургүй байдаг.

- Далд өгүүлэгдэхүүн бүхий хавсарсан өгүүлбэрүүд

Англи хэлэнд өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн гишиг нь хам сэдвийн хүрээнд илэрхий бол орхигдох тохиолдол байдаг. Эдгээр нь ихэвчлэн *non-finite* буюу *цаа/бие заагаагүй* гишиг өгүүлбэрүүд байх ба гол болон гишиг өгүүлбэрийн үйлийн эзэн ихэнх тохиолдолд нэг хүн байдаг.

Жишээ-3: *She hesitated, being very suspicious, to open the door.*

Эмэгтэйд ихэд сэжиг төрж хаалга тайлалгүй тээнсгэлээв.

Зарим тохиолдолд гишиг болон гол өгүүлбэрийн аль алинд үйлийн эзэн орхигдох нь бий.

Жишээ-4: *Since leaving her, life has seemed empty.*

Энэ тохиолдолд *life has seemed empty to me* гэж үзвэл -ing гишиг өгүүлбэрийн үйлийн эзэн мөн гол өгүүлбэрийн эзэн болж таарна.

Тэр эмэгтэйг хаяж явсанаас хойши амьдрал минь утгагүй хоосон санагддаг болоод байна.

Хэрэв хам сэдвийн хүрээнд үйлийн эзэн өөр хэн нэгэн хүн байгаа бол өгүүлбэр дараах байдлаар орчуулагдах нь дамжиггүй:

Тэр эмэгтэйг хаяж явсанаас хойши амьдрал нь утгагүй хоосон санагддаг болсон аж.

Энд нэг өгүүлбэрийн хувьд утгыг бүрэн гаргах боломжгүй байгаа нь илэрхий байна. Яагаад гэвэл энэ өгүүлбэрт буй эмэгтэй эхнэр нь байсан уу, найз охин нь байсан уу мон үйлийн эзэн түүнийг хаяж явсан уу эсвэл амьдралын эрхээр орхиж явсан уу гэдэг зөвхөн өргөн хам сэдвийн хүрээнд л ойлгомжтой болох билээ.

Жинээ-5: *Reading the evening paper, a dog started barking.*

Энэ жишээнээс харахад нохой сонин уншихгүй нь тодорхой тул гишүүн болон гол өгүүлбэрийн үлийн эзэд нэг байж таарахгүй тохиолдол байдал нь харагдаж байна.

*Оройн сонин уншиж байтал нохой хуцажс эхлэв.*

Ийм бүтэцгэй өгүүлбэрүүдийн үлийн эзэн монгол хэлэнд хамаатуулах утга заасан минь, тъхэллэгүүдээр (жишээ 4) илэрхийлэгдэн англи бүтэцгэй адилхан үлийн эзэнгүй орчуулагдаж байгаа (жишээ 4,5) нь төстэй байна.

**3. Өргөн хам сэдвийн хүрээнд утга гаргах**

Үү болон өгүүлбэрийн бүтцүүд нь зохиогчийн хувьд хамгийн гол зорилго болох яруу санааг илэрхийлэн гаргахад үйлчилдэг хэрэглэгдэхүүн юм хэмээн В.Хатим “Discourse and the translator” номондоо өгүүлжээ. Уран зохиолд зохиогчийн уншигчид хүргэх гэсэн санаа нь уг, өгүүлбэрээр амилан, бичвэрээс бичвэрт, бүлгээс бүлэгт утгын нарийн уялдаа холбоотойгоор өрнөж байдал. Иймд орчуулагч хүн эдгээрийг өргөн хам сэдвийн (макро түвшинд) хүрээнд няхуур судлан оорийн хэлний онцлог, ард түмний ахуй амьдралд ойр дот буулгах арга замыг эрэлхийлэх хэрэгтэй юм.

Зохиолд үйл явдлыг нуугдмал, далд болон битүү утгаар илэрхийлэх нь шууд утгаар заавал илэрхийлэх шаардлагагүй зарим үйл явдлын өриөл болон зохиолын баатруудын сэтгэл хөдлөлийг хооронд нь уялдуулж харилцан хамааралтай болгодог. “Үүнийг ялгаж танихын тулд орчуулагч “сонгол” тун сайтай байх ёстой.”<sup>37</sup>

Хам сэдэв орчуулгад ямар чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг утга зохиолын доктор, Хатагин Го. Аким дараах байдлаар товч тодорхой томъёолсон байна: “Хүүрнэл зохиолын айзам олон талтай бөгөөд зохиолын уран дурслэлийн тогтолцоотой туйлын нягт холбоотой байдал. Урт богино өгүүлбэр, зогсоц, цувраа цэг зэрэг нь баатрын сэтгэл тайвирах, үймрэх, догдлох, санаа бодол гэнэт хувирах зэрэг дотоод сэтгэлийн өөрчлөлтийг гаргаж, өөроор хэлбэл дүрийг сэтгэхүйн талаас иэн үзүүлэхэд тус дөхөм болдог. Орчуулагч хүүрнэлийн айзмыг олж, зөв өнгийг барьж авснаараа зохиолыг бүхэлд нь ойлгох тулхүүрийг олж авна.”<sup>38</sup> (1.84)

Кембриджийн их сургуулийн англи хэлний ахисан шатны сертификат олгох шалгалтын материалыас авсан дараах зохиолын хэсгийн орчуулгад уг болон өгүүлбэрийг орчуулахад хам сэдэв ямар үүрэг гүйцэтгэдэг болохыг үзүүлэхийг хичээлээ.

The landing cupboard is stacked high with what Glyn calls low-use material: conference papers and research papers including, he hopes, a paper that he needs right now for the article on which he is working. All of these go back to his postgraduate days, in no convenient sequential order but all jumbled up. A crisp column of *Past and*

*Present* magazine is wedged against a heap of tattered files. Forgotten students drift to his feet as he rummages, and lie reproachful on the floor. ‘Susan Cochrane’s contributions to my seminar have been perfunctory’... labeled boxes of aerial photographs showing archaeological sites are squeezed against a further row of files.

Шатны дээд хонгилын шүүгээ Глины бага хурлын илтгэлүүд, судалгааны ажлууд гэх мэт бараг хэрэг болоод байдаггүй бичиг цаасаар пиг дүүрэн байх агаад тэдгээрийг дээш нь өндөрлөн цэгцтэй байрлуулжээ. Тэрээр одоо бичиж байгаа өгүүлэлдээ ашиглах нэг цаасыг эндээс олдох байх хэмээн найдна. Эдгээр бичиг цааснууд түүний дэд эрдэмтний зэрэг хамгаалахдаа хийж байсан ажлууд бөгөөд тодийлэн дэс дараагаар нь бус энд тэнд хольж хадгалсан аж. Хавтас нь нугаларч үнгэгдээгүй “Өнгөрсон ба Одоо” сэтгүүлийн дугааруудыг хэсэг бөөн ноорхой бичиг цаас руу шахаж өрсөн байна. Эдгээрийг онгичтот мартагдаж одсон оюутнуудын ажлууд хөл рүү нь овоорон унаж түүнийг зэмлэх мэт шалан дээр хэвтэнэ. ‘Сузан Кокрен ч миний семинарын хичэлүүдэд ёс төдий л оролцдог байсан’... археологийн олдворт газруудын агаараас авсан гэрэл зурагнуудыг хадгалсан шошготой хайрцагнуудыг шахаж бас хэсэг бөөн бичиг цаасыг эгнүүлэн тавьжээ.

Энэ зохиолын хэсэгт Грин гэдэг хүн юу хийдэг, ямар мэргэжлийн салбарт ажилладаг, ажлын туршлага болон юмандаа хэр нямбай ханддаг болохыг түүний шүүгээндээ хадгалсан бичиг цаасны байдлаар өвөрмөц дүрслэн гаргасан байна. Мөн эндээс цаашид зохиолын баатруудын нэг байх магадлалтай Сузан Кокрен гэдэг дүрийг уран сайхны аргаар шигтгэн гаргаж иржээ.

‘Landing cupboard’ гэдэг үгийг сайн эрэл хайгуул хийж орчуулах хэрэгтэй болсон ба учир нь cupboard нь аяганы шүүгээ/эргэнэг гэж ойлгогддог байтал энд бичиг цаас хадгалсан байна. Мөн тодотгол гишүүний үүргээр орж байгаа ‘landing’ гэдэг уг энд ямар утгатай байгааг олох амаргүй байсан. Англичууд шатны дээд хэсэгт байдал шүүгээг ингэж нэрлэдэг бөгөөд ихэнхдээ ор дэрний даавуу хадгалах зориулаалттай байдал байна.

Энд зохиолч a heat of tattered files гэдгийг дараагийн өгүүлбэрт *forgotten students drift to his feet* хэмээн утгын нарийн сэжмээр холбож өгсөн байна. Эндээс ноорхой цааснууд оюутнуудын юм байна гэсэн битүү санааг зохиогч өгч байна. Энэ далд утгыг олж мэдсэнээр a crisp copy of *Past and Present* magazine is wedged against a heap of tattered files. Forgotten students drift to his feet as he rummages, and lie reproachful on the floor гэсэн хоёр өгүүлбэрийг утгын сэжмээр холбож монгол хэл рүү хөрвүүлэх боломжтой болж байна. Тэрнээс бус энэ хоёр өгүүлбэрийн англи хувилбарыг харахад Хавтас нь бараг шинээрээ байгаа “Өнгөрсон ба Одоо” сэтгүүлийн дугааруудыг давхарлан хэсэг бөөн ноорхой бичиг цаас руу шахаж тавьсан харагдана. Тэр онгичиж байтал мартагдсан оюутнууд хөл рүү нь овоорон унаж зэмлэнгүй байдалтай шалан дээр хэвтэнэ гэж орчуулах болж байна. as he rummages гэхэд тусагдахуун гишүүн байхгүй байгаа тул сэтгүүлээр хашигдсан бөөн ноорхой цаасыг онгичиж байгаа юмуу эсвэл сэтгүүлүүдийг онгичиж үзэж байсан уу гэдэг нь тодорхой бус тул орчуулагчийг хам сэдэвээ нарийн судалж шийдвэр гаргахад хүргэж байна. Монгол хэлэнд онгичих гэдэг үйл уг тусагдахуун заавал шаардаж байж утга бүрэн гарах хэрэгтэй болж байна.

<sup>37</sup> Г.Аким Орчуулгын санг уудлахад, УБ 1984 х.84

<sup>38</sup> Г.Аким Орчуулгын санг уудлахад, УБ 1984 мөн тэнд

Мөн англи хувилбарт *оюутнууд хөл рүү нь цуран орж ирж* гэхэд найруулга болон утгын хувьд уран сайхан илэрхийлэгдэж байгаа бол монгол хэлэнд оюутны хийсэн ажлууд хэмээн орчуулгын “*ицмэх аргыг*” хэрэглэн дэлгэрүүлэх хэрэгтэй байна.

#### Дүгнэлт

Аливаа орчуулга, тэр дундаа уран зохиолын орчуулгыг чанартай сайн хийхэд хам сэдвийн үүрэг асар их байдгийг олон орны орчуулагчид хүлээн зөвшөөрдөг. Энэ хам сэдэв гээд байгаа зүйл маань үндсэндээ эх зохиолын зохиогчийн өвөрмөц найруулгын арга, зохиолын аялга айзам, уран сайхнаар илэрхийлэх онцлогийг хэлээд байх шиг санагдана. Эдгээрийг цогцоор нь нарийн мэдэрч тэр эх хэлний яруу сайхан найруулгыг оорийн хэл дээр буулгадаг орчуулагч хүн мөн өөрөө уран сайхны мэдрэмжтэй, эх хэлний баялаг мэдлэгтэй байхаар тогтохгүй найруулан бичих авьяастай байх хэрэгтэй юм.

#### Ашигласан ном зүй.

1. Г.Аким. Орчуулгын санг уудлахад УБ 1984
2. Р.Гүрбазар. Орчуулгын онол, дадлагын үндэс. УБ 1996
3. Б.Дашдаваа. Уран зохиолын орчуулгын тухай. УБ 1988
4. Ц.Дашдондов. Монгол-Англи өвөрмөц хэлц. хэллэгийн толь. УБ 2001
5. Ц.Цэдэндамба. Орчуулгын үндэс. УБ 1979
6. D.Emery etc. English Fundamentals, New York, 1992
7. R. Quirk, S.Greenbaum, A university Grammar of English, Longman 1973
8. Б.Пүрэв-Очир. Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүйн холбох тогтолцоо УБ 1988
9. Ц.Сүхбаатар. Монгол хэлний найруулга зүй, УБ 1998
10. <http://www.cambridgeesol.org>
11. B. Hatim, Jeremy Munday, ‘Translation: Advanced resource book’ 2005
12. Abdolmehdi Riazi, ‘The invisible in translation: The role of text structure’, an article, source: Translation journal <http://accurapid.com/journal>
13. Cecilia Quiraga-Clare, ‘Language ambiguity’ Journal of translation Vol 2 number 2(2006) 43
14. Sang Zhonggang, ‘A Relevance theory perspective on translating the implicit information in literary texts’
15. Oxford advanced learner’s dictionary, Oxford University press, 2005
16. Оксфорд Монсудар English Mongolian dictionary Monsudar publishing, 2006